

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2026 ОНЫ 02 ДУГААР САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

2026 оны 02 дүгээр сарын 28-ны өдөр

Орхон аймаг

1. Үндсэн үйл ажиллагаа:

Аймгийн Засаг даргын 2025 оны А/17 захирамжаар 12 орон тоотой байгууллагын стратеги төлөвлөгөөний 5 зорилгын хүрээнд 2026 оны Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 зорилтын хүрээнд 44 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Байгууллагын “Эрсдэлийн үнэлгээний журам”-ын дагуу 2026 оны Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан 55 байгууллагаас 2025 оны 2 дугаар сарын 28-ний өдрийн байдлаар 4 байгууллагын хяналт шалгалт бүрэн дууссан, 6 байгууллагын хяналт шалгалт 30-90%-тай үргэлжилж байна.

Дотоод аудит, хяналт шалгалтын төрөл

Он	ДА, СХШ-ын төлөвлөгөө /төлөвлөгөөт бус тоо/	2026.02.28-ны байдлаар батлагдсан удирдамжийн тоо	Төлөвлөгөөт	Төлөвлөгөөт бус	Дотоод аудит	Санхүүгийн хяналт шалгалт
2026	55	10	10	-	7	3

2026 оны бүрэн дууссан хяналт шалгалтын төлөвлөгөөний биелэлт 7.3 %-тай байна.

-Шалгалт бүрэн дууссан байгууллагууд:

1. Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ
2. Их шүтээн ОНӨААТҮГ
3. Үйлс бадрах ӨЭМТөв
4. Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сан

Дээрх байгууллагуудын гүйцэтгэсэн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, дүгнэлтийг байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч нарт танилцуулж, тогтоосон акт, албан шаардлага, ажил сайжруулах зөвлөмжийн биелэлтийг тогтоосон хугацаанд хангуулан ажиллаж байна.

-Шалгалт бүрэн дуусаагүй байгууллагууд:

1. 2-р цэцэрлэг
2. 5-р цэцэрлэг
3. 16-р цэцэрлэг
4. 20-р цэцэрлэг
5. Жаргалант сумын Хоршоо хөгжүүлэх сан
6. 11-р цэцэрлэг

Дээрх байгууллагуудын 2025 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг гүйцэтгэж байна.

Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 85 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар дотоод аудит гүйцэтгэлээ. (Засгийн газрын тусгай сан-3, Орон нутгийн төсвийн байгууллага-73, ОНӨХК-2,

ОНӨААТҮГазар-5, Баян-Өндөр сум, ЖаргалантI сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурал-2). 2025 оны 3-р улирлаас Орхон аймгийн Архивын хэлтэс нэмэгдэж, Шилэн дансны нэгдсэн цахим системд 61 талбарт мэдээлэл байршуулж, дотоод аудитад хамрагдсан. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нэгдсэн дүн **98.2%** байна.

Үүнд:

- Хуулийн хугацаа хоцроож мэдээлэл байршуулсан байдал: 64 байгууллага 181 талбарт хуулийн хугацаа хоцорч мэдээлэл байршуулж **98.7%** байна.
- Мэдээлсэн талбараас дутуу буюу иж бүрэн бус мэдээлсэн талбар: 44 байгууллага 71 талбарт иж бүрэн бус мэдээлэл байршуулж **99.4%** байна.

85 байгууллагаас:

- 13 байгууллага 100%,
- 68 байгууллага 95-99%,
- 4 байгууллага 90-94% тус тус дүгнэгдлээ.

Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 зорилт, 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн боловсруулж 2026.02.03-ны өдөр аймгийн Засаг даргатай гэрээ байгуулсан.



Газрын дарга 2026.02.04-ны өдөр 2026 оны Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг албан хаагчидтай баталлаа.



“Бүх хайраа гэр бүлдээ” төслийн хүрээнд байгууллага дээрээ сарын аяны төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллалаа. Аянтай холбогдох тайланг 2026.02.11-ний өдөр Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар”-т хүргүүлсэн.

3. Шагай няслах тэмцээнд 11-18 насны хүүхдүүд:



4. Шагай шүүрэх тэмцээнд эцэг эхчүүд:



2. Сургалт, зөвлөгөөн:

- 2026.02.05-ны өдөр "БҮХ ХАЙРАА ГЭР БҮЛДЭЭ" төслийн нээлтийн үйл ажиллагаанд байгууллагын "Эцэг эхийн зөвлөл" оролцсон.



- 2026.02.05-ны өдөр “Насан туршийн суралцахуйн төв”-тэй хамтран “Гар утсаа ашиглан цахим орчинд үндэсний бичгээр бичих” сэдэвт дотоод сургалтыг зохион байгууллаа.



- 2026.02.05-ны өдөр "Стандарт, хэмжил зүйн хэлтэс"-ээс "MNS 7068:2025, Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага стандартын танилцуулах" сургалт зохион байгууллаа. Мөн "Байгууллагын стандарт"-аа шинэчлэн батлах талаар зөвлөн туслах үйлчилгээ авлаа.



2. Үүрэг даалгавар:

- 2026.02.06-ны өдөр байгууллагын бүх албан хаагчид өөрсдийн албан өрөө тасалгаа, нийтийн эзэмшлийн талбайдаа “Их цэвэрлэгээ” зохион байгуулсан.



- **Засаг даргын өргөтгөсөн хурал 2026-01-30 үүрэг даалгавар:** "Бүх хайраа гэр бүлдээ төсөл"-ийн нээлтийг зохион байгуулах. Байгууллагууд тус арга хэмжээнд идэвхтэй оролцох

Биелэлт: "Бүх хайраа гэр бүлдээ" төслийн хүрээнд зохион байгуулсан ажлын төлөвлөгөө, тайланг 2026.02.05-ны өдөр Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт цаасаар болон файлаар хүргүүлсэн.

- **Засаг даргын өргөтгөсөн хурал 2026-02-06 үүрэг даалгавар:** Байгууллагууд сар шинийн баярын өдрүүдэд ажиллах хариуцлагатай жижүүр томилох, яаралтай үед авах арга хэмжээний төлөвлөгөө батлуулан ажиллах.

Биелэлт: Байгууллагын даргын 2026.02.10-ны өдрийн А/07 дугаартай тушаалаар Сар шинийн баярын өдрүүдэд ажиллах хариуцлагатай жижүүрийг томилж, яаралтай үед авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган ажилласан. Хариуцлагатай жижүүрээр ажилласан тайланг аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ болон ХШҮХ-т 2026.02.24-ний өдөр хүргүүлсэн.



Энхтуяа Махвал

· Хоёрдугаар сарын 17 өдрийн 20:29 цаг · 🌐

2026.02.17-ны хариуцлагатай жижүүрийн үүргийг гүйцэтгэж дууслаа. цонх хаалга бүтэн ямар нэгэн эрсдэлт зүйл байхгүй ажлын байрууд тайван байна. Жижүүрийн дэвтэр Нягтлан Нямжаргалын өрөөнд түлхүүрийг жижүүрт үлдээлээ.

Та бүхэн минь сар шинэдээ сайхан шинэлээрэй.



Oyu Zulaa

· Хоёрдугаар сарын 20 өдрийн 14:21 цаг · 🌐

Сайхан шинэлцгээж байна уу? 2026.02.20-ны хариуцлагатай жижүүрийг хийж гүйцэтгэлээ. Хаалга, цонх хэвийн эвдрэл гэмтэлгүй. Ус алдсан эрсдэл гарсан зүйлгүй. Ажлын байр та... Цааш үзэх



САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР